



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорнод аймаг дахь Политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж болох 10 нэрийн, нийт 25,365,773.00 (хорин таван сая гурван зуун жаран таван мянга долоон зуун далан гурван) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 23,014,539.00 (хорин гурван сая арван дөрвөн мянга таван зуун гучин есөн) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Дорнод аймаг дахь Политехник коллежийн захирлын үүргийг гур орлон гүйцэтгэгч Т.Сүмбэрт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
 газрын 2022 оны 6-дугаар сарын 23-ны өдрийн
 62-дугаар тогтоолын хавсралт

ДОРНОД АЙМГИЙН ПОГИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГТҮЙ,
 АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нийт балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл ертег	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ	Шинэчлэн тогтоосон нийт үнэ	Цаашид ашиглах хугацаа (жил)
1	CD хувиргагч төхөөрөмж	11/14/2012	2	4,008,265.00	4,008,265.00	-	1,202,479.50	2,404,959.00	3
2	Компьютер, мэдрэгчтэй	11/14/2012	2	2,546,916.00	2,546,916.00	-	764,074.80	1,528,149.60	3
3	Суурин компьютер	11/14/2012	22	2,133,056.00	2,133,056.00	-	639,916.80	14,078,169.60	3
4	Таблет, Wasom	11/14/2012	1	4,034,977.00	4,034,977.00	-	1,210,493.10	1,210,493.10	3
5	Зөөврийн компьютер	11/14/2012	1	1,491,401.00	1,491,401.00	-	447,420.30	447,420.30	3
6	Телевизор Panasonic 32 инч	11/14/2012	1	680,064.00	680,064.00	-	204,019.20	204,019.20	3
7	Босоо компьютер	11/14/2012	1	6,444,951.00	6,444,951.00	-	1,933,485.30	1,933,485.30	3
8	Компьютер ширээ	11/14/2012	1	933,212.00	933,212.00	-	279,963.60	279,963.60	3
9	Агааржуулагч	11/14/2012	1	2,133,056.00	2,133,056.00	-	639,916.80	639,916.80	3
10	Хурлын ширээ	11/14/2012	1	959,875.00	959,875.00	-	287,962.50	287,962.50	3
				25,365,773.00	25,365,773.00	-	-	23,014,539.00	-
Нийт дүн				(хорин таван сая гурван зуун жаран таван мянга долоон зуун далан гурван)		-	-	(хорин гурван сая арван дөрвөн мянга таван зуун гучин есөн)	-